



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2017.04.28 № 05

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЖАРГАЛТУЛГЫН ЭРДЭНЭБАТ  
ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлаас 2012 онд баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглосон билээ.

Гэвч мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хэд хэдэн удаагийн шалгалтаар зөвшөөрөлгүй цэгт тамхи худалдах зөрчил нийтлэг байгаа нь илэрсэн байх бөгөөд орон сууц, сургуулийн ойролцоох хүнсний дэлгүүр, түргэн үйлчилгээний цэг болон гар дээрээс ширхэглэн худалдаж байгаа нь тогтоогдсон байдаг.

Хууль бус тамхины худалдаа нь төрийн албан хаагчдын дунд авилга хүнд суртлыг нэмэгдүүлэх, түүнийг дагасан хууль бус наймааны шинжтэй бүлэглэл бий болох, хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг өндөр үнээр худалдаалах зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгож байгаа нь олон нийт болон тамхи хэрэглэгчдийн дунд ил болоод байна.


Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулийг дээдлэн хүндэтгэх, сахин биелүүлэх үүрэг, зарчмыг алдагдуулах, цагдаагийн албан хаагчдын нэр хүнд унах нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн байдлын талаар асуулгыг тавьж байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Н.УЧРАЛ